

ДОТООД АУДИТЫН ЖУРАМ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Дотоод аудитын журам /цаашид “Журам” гэх/-ын зорилго нь “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн (цаашид “Компани” гэх) дотоод аудитын зорилго, үйл ажиллагаа, төлөвлөлт, хэрэгжилт, түүний бүтэц, зохион байгуулалт, эрх үүрэг, хариуцлага, бусад газар, нэгжтэй хамтран ажиллах харилцааг зохицуулна.
- 1.2. Дотоод аудит нь системтэй, оновчтой арга хандлагаар компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж, компанийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах, удирдлагад зөвлөх үйл ажиллагаа байна.
- 1.3. Компани нь стратегийн зорилго, зорилтод хүрэхэд учирч болох эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлсний үр дүнд дотоод аудитын бодлогыг тодорхойлж түүний дагуу төлөвлөнө.
- 1.4. Энэхүү журам нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцсэн болно.
- 1.5. Энэхүү журам болон түүний нэмэлт, өөрчлөлт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд Компанийн нийт ажилтнууд дагаж мөрдөнө.
- 1.6. Энэхүү журмын хэрэгжилтэд Гүйцэтгэх удирдлага, дотоод аудитын нэгж хяналт тавьж ажиллана.

2. ДОТООД АУДИТЫН ЗАРЧИМ

- 2.1. Дотоод аудит нь үйл ажиллагааг үр дүнтэй байлгахын тулд дараах зарчмыг баримтална. Үүгээр хязгаарлагдахгүй.
 - 2.1.1. Шударга байх;
 - 2.1.2. Мэдлэг чадвар, мэргэжлийн ур дүйг илтгэн харуулах;
 - 2.1.3. Бодитой хандах, зохисгүй нөлөөллөөс ангид (хараат бус), бие даасан байх;
 - 2.1.4. Компанийн стратеги, зорилт, эрсдэлд ажлаа чиглүүлэх;
 - 2.1.5. Компанид зохих байр суурь эзэлж, хангалттай нөөцтэй байх;
 - 2.1.6. Дотоод аудитын үйл ажиллагааны чанарын ба тасралтгүй сайжруулалтыг илтгэн харуулах;
 - 2.1.7. Холбогдох талуудтай үр нөлөөтэй харилцах;
 - 2.1.8. Эрсдэлд суурилсан баталгаа өгөх;
 - 2.1.9. Шинийг эрэлхийлсэн, санаачилгатай, ирээдүйг харсан байх;
 - 2.1.10. Компанийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн байх.

3. ДОТООД АУДИТЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 3.1. Компани нь дотоод аудит хариуцсан нэгжтэй байна. Дотоод аудитын нэгж нь компанийн бүхий л үйл ажиллагааны түвшинд эрсдэлд суурилсан дотоод аудитын үйл ажиллагааг явуулах бөгөөд дараах чиглэлтэй байна. Үүнд:
 - 3.1.1. Компанийн засаглалын үйл явцыг үнэлж, сайжруулах зөвлөмж өгөх;
 - 3.1.2. Эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй ба үр ашигтай байдлыг үнэлэх сайжруулах;
 - 3.1.3. Дотоод хяналтын системийн үр нөлөөтэй ба үр ашигтай байдлыг үнэлэх, сайжруулах;
 - 3.1.4. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, мөрдөж буй заавар журмын дагуу үнэн зөв тайлагнаж буй эсэхэд баталгаажуулалт өгөх;



- 3.1.5. Худалдан авах үйл ажиллагаа, түүний хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд хяналт тавих;
- 3.1.6. Компанийн үйл ажиллагааны ил тод байдалд хяналт тавих;
- 3.1.7. Бусад газар, нэгжүүдэд хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдал, хэрэгжилт.

4. ДОТООД АУДИТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1 Аудитын хорооноос санал болгосноор компанийн дотоод аудитын нэгжийн дарга, ажилтнуудыг төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилно.
- 4.2 ТУЗ нь дотоод аудитын үйл ажиллагааг дараах байдлаар хариуцаж ажиллана. Үүнд:
 - 4.2.1. Дотоод аудитын бодлогыг тодорхойлох, батлах, түүнийг өөрчлөх;
 - 4.2.2. Эрсдэлд суурилсан дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг хянах;
 - 4.2.3. Дотоод аудитын нэгжийн орон тоо, төсөв, удирдлага, ажилтнуудын цалин, урамшууллыг тогтоох;
 - 4.2.4. Дотоод аудитын нэгжийн ажиллах журам, дүрэм, гарын авлагыг батлах;
 - 4.2.5. Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаа нь компанийн үйл ажиллагаанд эергээр нөлөөлж, туслалцаа дэмжлэг үзүүлж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 4.2.6. Дотоод аудитын тайлан, дүгнэлттэй тухай бүр танилцаж, аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу авах арга хэмжээнүүдийн талаар шийдвэр гаргах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 4.2.7. Дотоод аудитын тогтолцоо, үйл ажиллагааг Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартаар тогтоосон хэлбэрээр зохион байгуулж, хэрэгжүүлж чадаагүйгээс компанид ноцтой эрсдэл учирсан болон учирч болзошгүй нөхцөл байдал үүссэн бол дотоод аудиторт хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авах;
 - 4.2.8. Хуульд заасан бусад.
- 4.3 Гүйцэтгэх удирдлага, ажилтнууд нь дотоод аудитын нэгжтэй дараах байдлаар хамтран ажиллана. Үүнд:
 - 4.3.1. Дотоод аудитын нэгжийг хараат бусаар ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангаж, ажилд нь хүндрэл учруулахгүй байх;
 - 4.3.2. Дотоод аудитын удирдамжид зааснаар дотоод аудиторын шаардсан мэдээ, материал, лавлагаа, тайлбарыг аудит хийлгэж байгаа нэгжийн удирдлага, ажилтнууд холбогдох дүрэм, зааврын дагуу хугацаанд нь гаргаж өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд ярилцлага, санал асуулгад оролцох;
 - 4.3.3. Дотоод аудитаар гарсан зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах;
 - 4.3.4. Хуульд заасан бусад.
- 4.4 Дотоод аудитын нэгж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.4.1. Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ажиллах дүрэм, журам, гарын авлагыг боловсруулж, ТУЗ-өөр батлуулан, хэрэгжүүлэх;
 - 4.4.2. Хууль тогтоомж, бодлогын баримт, дүрэм, журам, дотоод аудитын олон улсын стандартын дагуу дотоод аудитыг гүйцэтгэх;
 - 4.4.3. Дотоод аудитын тайланг гүйцэтгэх удирдлагад танилцуулж, баталгаажуулсны дараагаар Аудитын хороогоор хэлэлцүүлэх;
 - 4.4.4. Эрсдэлд суурилсан дотоод аудитыг гүйцэтгэж, компанийн өндөр эрсдэлтэй хэсгүүдэд ажиллах;

- 4.4.5. Дотоод аудитыг мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу явуулах ба компанийн нэгжийн ажилтнуудаас ярилцлага, асуулга, лавлагаа, тодруулга авч, ажлын баримтад тулгуурлан үнэн зөв, бодитой үнэлгээ, дүгнэлт гаргах;
- 4.4.6. Дотоод аудитын нэгжийн удирдлага нь дотоод аудитыг тогтоосон хугацаанд чанартай, үр дүнтэй байхаар ажлын хэсгийг зохион байгуулахын зэрэгцээ ажлын явц, гүйцэтгэлийн талаар болон шаардлагатай гэж үзсэн тохиолдолд аудитын удирдамжид өөрчлөлт оруулах саналаа ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэх;
- 4.4.7. Дотоод аудитыг хийхдээ шалгуулагчийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр явуулах;
- 4.4.8. Компанийн дүрэм, журамд заасан бусад.
- 4.5. Дотоод аудитын нэгжийн удирдлага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.5.1. Нэгжийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих;
 - 4.5.2. Нэгжийн нэн тэргүүнд анхаарах асуудлуудыг илрүүлж, эрсдэлд суурилсан дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулах;
 - 4.5.3. Дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар дээд удирдлагатай шууд харилцах;
 - 4.5.4. Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хангалттай, зохистой нөөцийг бүрдүүлэх, хуваарилах;
 - 4.5.5. Дотоод аудитыг төлөвлөсөн хугацаанд дуусгах, тайлагнах явцыг хянаж, удирдах;
 - 4.5.6. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэх удирдлагаас үр нөлөөтэй хариу арга хэмжээ авсан эсэх талаар байгууллагын дээд шатны удирдлагад тогтмол тайлагнах;
 - 4.5.7. Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй, зохистой байдлын талаар нэгдсэн дүгнэлт гаргах, тайлагнах;
 - 4.5.8. Аудиторын сургалт, хөгжүүлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
 - 4.5.9. Хууль, дүрэм, журамд заасан бусад.
- 4.6. Дотоод аудитор нь аудитыг төлөвлөх, хэрэгжүүлэх болон тайлагнах үүргийг хүлээж, дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.6.1. Дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан аудитыг гүйцэтгэх;
 - 4.6.2. Дотоод аудитын стандартад заасан мэргэжлийн ёс зүй,
 - 4.6.3. Хараат бус байдлын шалгууруудыг хангаж ажиллах;
 - 4.6.4. Эрсдэлд суурилсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах;
 - 4.6.5. Аудитын явцад бүрдүүлсэн нотолгоо, ажлын баримтыг нягтлах, архивд хүлээлгэн өгөх;
 - 4.6.6. Хууль, дүрэм, журамд заасан бусад.

5. ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨЛТ

- 5.1. Дотоод аудитын нэгж нь дотоод аудитын нэн тэргүүнд анхаарах асуудлыг тодорхойлохын тулд компанийн стратеги, зорилго, зорилттой уялдсан эрсдэлд суурилсан төлөвлөгөө гаргана.
- 5.2. Эрсдэлд суурилсан төлөвлөгөө боловсруулж компанийн дээд шатны удирдлага болон гүйцэтгэх удирдлагатай санал солилцоно.
- 5.3. Дотоод аудитын төлөвлөгөө нь дараах хугацаатай байна. Үүнд:
 - 5.3.1. Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө /2-3 жил/;
 - 5.3.2. Дотоод аудитын жилийн төлөвлөгөө /1 жил/ байна.
- 5.4. Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаандаа ашиглах дээрх төлөвлөгөөнүүдийг боловсруулахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 5.4.1. Эрсдэлийн үнэлгээнд суурилсан байх;

- 5.4.2. Компанийн стратеги, зорилго, зорилттой уялдсан байх;
- 5.4.3. Баримт, нотолгоотой байх;
- 5.4.4. Хангалттай, үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн байх;
- 5.4.5. Мэдээллийг цуглуулж, шинжилгээ хийсэн байх.
- 5.5 Дотоод аудитын хамрах хүрээнд шаардагдах нөөц, хугацааг тооцож, төлөвлөхийн тулд аудит хийх давтамжийг дараах байдлаар төлөвлөнө. Үүнд:
 - 5.5.1. Их эрсдэлтэй объектыг жил тутам;
 - 5.5.2. Дунд эрсдэлтэй объектыг хоёр жил тутамд нэг удаа;
 - 5.5.3. Бага эрсдэлтэй объектыг гурван жилд тутамд нэг удаа.

6. ДОТООД АУДИТЫН ХЭРЭГЖИЛТ

- 6.1. Дотоод аудит нь дараах үйл ажиллагааны бүх шатанд хэрэгжинэ. Үүнд:
 - 6.1.1. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа;
 - 6.1.2. Дотоод хяналт;
 - 6.1.3. Эрсдэлийн удирдлага;
 - 6.1.4. Компанийн бусад нэгжийн удирдлагын үйл ажиллагаа;
 - 6.1.5. Компанийн ажилтны үйл ажиллагаа.
- 6.2. Дотоод аудитын үйл явц нь дараах үе шаттайгаар хэрэгжинэ. Үүнд :
 - 6.2.1. Урьдчилан үнэлэх;
 - 6.2.2. Аудитыг төлөвлөх
 - 6.2.3. Аудитыг гүйцэтгэх;
 - 6.2.4. Аудитын үр дүнг тайлагнах;
 - 6.2.5. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах.

7. ХАРИУЦЛАГА

- 7.1. Хөндлөнгийн аудитаас дотоод аудитын үйл ажиллагаанд гаргасан үнэлгээний дагуу дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулна.
- 7.2. Журмыг зөрчсөн аудиторын үйлдэл нь компанид эд хөрөнгийн хохирол учруулсан бол түүнд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэж, холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авна.
- 7.3. Энэхүү журамд заагаагүй асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэнэ

8. БУСАД

- 8.1 Дотоод аудитын мэргэжил, практикийн олон улсын өөрчлөлт, хөндлөнгийн аудитын дүгнэлт, ТУЗ, түүний дэргэдэх Аудитын хорооны саналд үндэслэн дотоод аудитын бодлогод өөрчлөлт орж болно.